



“ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН”

Баян Хөндий алтны хайгуулын төслийн талбайд өндөр агуулга бүхий бүс эрчимтэй үргэлжилж буйг баталлаа. Үүнд 2.6 г/т алттай 143 м, 57 г/т алттай 4 метр интервалууд багтаж байна.

Канад улс, Нова Скошиа муж, Халифакс хот – 2018.06.14

Эрдэнэ Ресурс Девелопмент Корп. (TSX:ERD | MSE:ERDN) (цаашид “Эрдэнэ” эсвэл “Компани” гэх) нь Монгол Улсын баруун өмнөд бүсэд байрлах, компанийн 100% эзэмшлийн Баян Хөндий алтны хайгуулын төсөл (“Баян Хөндий”)–н талбайд гүйцэтгэсэн 2018 оны 2-р улирлын хайгуулын өрөмдлөгийн ажлын хоёрдугаар хэсгийн үр дүнг тайлагнахад таатай байна.

“Мидфийлд бүсэд хийгдсэн өрөмдлөгийн судалгаагаар бага агуулгатай хүдэржилтийг өндөр агуулга бүхий алтны өргөн интервал хүрээлж байгааг баталлаа” хэмээн Компанийн Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх захирал Петер Акерли хэлээд, мөн: “Энэхүү өндөр агуулгатай бүсүүд, металлургийн эерэг үр дүнгүүд нь оны эцэст хийгдэх урьдчилсан эдийн засгийн тооцоолол болон анхан шатны нөөцийн тайланд эерэг нөлөө үзүүлнэ гэдэгт бид итгэлтэй байна. Өнөөдрөөс эхлэн Баян Хөндий болон залгаа орших Улаан тусгай зөвшөөрлийн талбайд 2,500 тууш метрийн өрөмдлөгийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, хайгуулын өрөмдлөг хийхээр төлөвлөж байна” гэж мэдэгдлээ.

Онцлох үр дүн

(План зураг болон хөндлөн зүсэлтийг хавсралтаас харна уу.)

- Мидфийлд бүс дэх баруун хойш чиглэлтэй гүний хагарал болон солбицох хавтгайн структур хоёрын огтлолцол хэсэгт тэжээгч бүс байгаа гэсэн онолыг шалгаж өрөмдөхөд дунджаар 34.4 г/т алтны агуулгатай 7 метр бүс огтлогдсон нь өнөөгийн байдлаар мэдэгдэж буй алт агуулсан кварц-адулярын судалтай хамгийн өргөн бүс болоод байна.
- Мидфийлдийн өндөр агуулгатай бүс эрчимтэй үргэлжилж буйг бүх 4 цооног дөрвүүлээ (BKD-242-оос BKD-245) баталгаажуулсан бөгөөд 67 метрээс 143 метрийн хооронд 2.2 г/т-с дээш алтны агуулгатай өндөр интервалууд огтлогдлоо.
- Мидфийлд бүсэд өрөмдсөн 4 цооног нь газрын гадаргаас 100 метрээс ихгүй гүнд маш өндөр агуулга бүхий олон интервалуудыг огтолсон. Үүнд:
 - 56.8 г/т алттай 2 метр (BKD-242),
 - 90.5 г/т алттай 1.3 метр (BKD-243),

- 57.1 г/т алттай 4 метр (BKD-244), ба
- 35.6 г/т алттай 3 метр (BKD-245)
- Хойд Мидфийлд бүсийг зүүн хойд зүгт тэлэхээр өрөмдсөн нэг цооногт энэ хэсэгт мэдэгдэж буй хамгийн өндөр агуулга илэрлээ:
 - 50.5 г/т алттай 2 метрийг агуулсан, 4.4 г/т алттай 37 метр (BKD-241)
- Баян Хөндийн өрөмдлөгийн ажлын 9 цооногийн үр дүн хүлээгдэж байгаа ба үр дүнг 2-3 долоо хоногийн дотор танилцуулна.
- Баян Хөндий болон Улаан тусгай зөвшөөрлийн талбайд хийгдэх 2,500 тууш метрийн өрөмдлөгийн ажил өнөөдрөөс эхэллээ.

Баян Хөндийн өрөмдлөгийн ажлын дүгнэлт

2018 оны 4-р сарын 11-нд эхэлсэн Компанийн 2018 оны 2-р улирлын хайгуулын өрөмдлөгийн ажил нь дараах зорилтуудтай. Үүнд:

- Хойд Мидфийлд болон Мидфийлд бүсүүд дэх өндөр ач холбогдол бүхий структур талбайнуудыг шалгах;
- Страйкер, Баруун Страйкер, Мидфийлд болон Хойд Мидфийлд бүсүүд дэх өрөмдлөгийн торыг нягтруулах;
- 1.4 км урттай талбайнхаа хүрээнд алтны хүдэржилттэй бүсүүдийн үргэлжлэл байж болох хэтийн төлөвт талбайнуудыг үргэлжлүүлэн шалгаж сонгох зэрэг багтана.

Өнөөдрийн мэдээгээр нийт 1,332 тууш метр бүхий 7 цооног (BKD-241-ээс BKD-247)-ийн үр дүнг танилцуулж байна. Үүнд: Мидфийлд бүсэд 4 цооног, Хойд Мидфийлд бүсэд 1, Хойд Мидфийлд бүсийн үргэлжлэл дээр 1, мөн Мидфийлд бүсийн баруун хязгаарыг шалгахад 1 цооногийг тус тус өрөмдсөн. Бүх цооногуудыг 45-65 градусын налуутайгаар өрөмдсөн ба алтны өндөр агуулгатай кварцын судлууд болон хүдэржсэн брекчийг хөндлөн огтлохоор төлөвлөгдсөн.

Хүснэгт 1-т эдгээр 7 цооногуудын үр дүнгийн онцлох хэсгүүдийг оруулсан ба үр дүнгийн тайлбарыг мөн хавсаргасан. Мөн хавсралтаас план зураг болон хөндлөн зүсэлтийг харна уу.

Хүснэгт 1. Баян Хөндийн өрөмдлөгийн ажлын үр дүнгийн онцлох хэсгүүд

Цооногийн дугаар	Хэдээс (м)	Хүртэл (м)	Интервал (м) ⁽¹⁾	Алт (г/т)
BKD-241	65	194	129	1.48
түүндээ	68	105	37	4.35
түүндээ	75	77	2	50.5
BKD-242	41	122	81	2.74
түүндээ	60	61	1	15.4
түүндээ	112	122	10	16.9
түүндээ	113	115	2	17.5
түүндээ	120	122	2	56.8
BKD-243	66	87	21	2.39
түүндээ	81	83	2	18.0
ба	110.7	178.1	67.4	2.83
түүндээ	118	119.3	1.3	90.5

Цооногийн дугаар	Хэдээс (м)	Хүртэл (м)	Интервал (м) ⁽¹⁾	Алт (г/т)
түүндээ	132	133	1	25.9
BKD-244	27	169.8	142.8	2.64
түүндээ	79	91	12	3.20
түүндээ	81	82	1	10.9
түүндээ	109	116	7	34.4
түүндээ	112	116	4	57.1
BKD-245	63	150	87	2.23
түүндээ	80	92	12	11.0
түүндээ	81	84	3	35.6
BKD-246	156	212	56	0.25
BKD-247	Тодорхой хүдэржилт илрээгүй			

(1) Хүснэгтэнд байх интервалууд нь жинхэнэ зузаан биш болно. Одоогоор хүдрийн системийн хэлбэр болон түүний огторгуйн байршлыг тооцоолох хангалттай өгөгдлийн сан байхгүй байна. Цооногууд нь хойш-баруун хойш зүгт -45-аас -65 градусын уналын өнцөгтэйгөөр өрөмдөгдсөн. Баян Хөндийн хүдэржилт нь дунд зэргийн уналтай (ойролцоогоор 40-50 градусын өнцгөөр баруун урагш унасан байршилтай).

Өрөмдлөгийн ажлын үр дүнгийн хэлэлцүүлэг

Дээр дурдсан 7 цооног нь Мидфийлд болон Хойд Мидфийлд бүс дэх өндөр агуулга бүхий хүдэржилтийн үргэлжлэл болон боломжит тэлэлтийг тогтоох, мөн нэмэлт структурын талбайнуудыг шалгах аар төлөвлөгдсөн. Баян Хөндий хайгуулын талбайн голлох бүсүүд, тэр дундаа Страйкер, Мидфийлд болон Хойд Мидфийлд бүсүүд нь маш өндөр алтны агуулгатай судлууд болон брекчийн бүсүүдийг үүсгэсэн бие даасан тэжээгч бүсүүдийн ойролцоо үүссэн байх боломжтой бөгөөд харьцангуй онцлог хүдэржилттэй байдаг.

Мидфийлд бүс

Страйкер болон Хойд Мидфийлд бүсүүдийн хооронд байх Мидфийлд бүс нь Баян Хөндийн алтны агуулга хамгийн жигд хүдэржсэн бүсэд тооцогдож байна. Энэ бүсийг шалгах аар өрөмдсөн 4 цооног (BKD-242-оос BKD-245)-т бүгдэд нь 67-143 метрийн интервалын хүрээнд 2.2 г/т-с дээш алттай бүсүүд огтлогдсон, тухайлбал 2.6 г/т алтны агуулгатай 143 метр хүртэл зузаан интервалд илэрлээ. Дээрх хүдэржсэн бүсүүд нь дотроо алтны өндөр агуулга бүхий олон дундын бүсүүдийг агуулж байна. (Хүснэгт 1-ийг харна уу)

Боломжит тэжээгч бүсүүдийг шалгах аар хийгдсэн эдгээр 4 цооногийг хянагч структурын дагуу ойролцоогоор 200 метр, өргөөшөө 25 метр талбайд, ойролцоох цооногуудаас 10-15 метр зайтайгаар хүдэржсэн судлуудын уналын чиглэлд перпендекуляр огтлохоор өрөмдсөн. Алтны хүдэржилттэй бүс нь Мидфийлд бүсийн урд хязгаарт газрын гадаргаас доош 20 метрт байх ба хойд зүгт цэрдийн хучаас доор ойролцоогоор 60 метр болон гүнзгийрдэг. BKD-245 цооногт огтлогдсон 35.6 г/т алттай 3 метрийг агуулсан 2.2 г/т алттай 87 метр огтлол нь Мидфийлд бүсийн өндөр агуулгатай хүдэржилт хойд зүгт цааш үргэлжилж буйг баталлаа.

Мидфийлд бүс дэх хянагч структурын боломжит баруун үргэлжлэл дээр ганц цооног (BKD-247) өрөмдсөн ба энэ цооногт тодорхой хүдэржилт илрээгүй. Энэ нь хянагч структурын дагуу алт агуулагч уусмал дамжин хойш, урагш, зүүн тийш нэвчсэн боловч баруун хэсгийн галт уулын агуулагч чулуулагт багахан нэвчсэн гэх таамаглалд хүргэж байна.

Хойд Мидфийлд бүс ба Хойд Мидфийлд бүсийн тэлэлт

ВКD-241 цооногийг Хойд Мидфийлд бүсийн зүүн хойд хэсэгт өрөмдсөн. Энэ нь 2018 оны 5-р сарын 8-нд өрөмдсөн сүүлийн цооногоос зүүн хойд зүгт 80 метрийн зайд байрлана. Энэ цооногт 50.5 г/т алттай 2 метр, түүнийг агуулсан 4.35 г/т алттай 37 метр огтлогдсон. Энэ үр дүн нь өмнөх цооногуудын үр дүн (2-р улирлын өрөмдлөгийн ажлын эхний шатанд өрөмдсөн ВКD-240 цооногт огтлогдсон 1.9 г/т алттай 34 метр болон зүүн хойд зүгт байх ВКD-182 цооногт огтлогдсон 65 г/т хүртэл алттай 1 метрийг агуулсан 39 метр)-г ихээхэн нэмэгдүүллээ. Боломжит тэжээгч структурууд дээр нягтруулсан торлолтой өрөмдлөгийн ажил хийснээр өндөр агуулга бүхий хүдэржилтийг илрүүлэхэд чухал ач холбогдолтой гэдгийг мөн харууллаа. Үүнээс зүүн хойш 100 м зайд өрөмдсөн ганц цооног (ВКD-246)-г 0.25 г/т алттай 56 метр буюу аномаль утга огтлогдсон.

Хянагч структурын тайлал

Одоогийн хийгдэж буй өрөмдлөгийн ажил нь 2017 оны 4-р улиралд хийгдсэн Баян Хөндий төслийн структурын судалгаанд тулгуурлан төлөвлөгдсөн. Энэ судалгаагаар алтны хүдэржилт нь зүүн хойш чиглэлтэй 2 тэлэлтийн хагарлын хооронд үүссэн хэд хэдэн баруун урагш уналтай структурууд буюу солбицох хавтгайн структуртай холбоотой байх ба солбицох хавтгай болон баруун хойш чиглэлтэй гүний хагарлын огтлолцол дээр хамгийн их ан цавшил үүссэн байж болохыг харуулсан. Энэ 2-р улирлын өрөмдлөгийн ажил нь өмнөх ажлаар илэрсэн 2,200 г/т алттай 1 м хүртэл агуулгыг агуулсан 158 г/т алттай 14 метрийг огтолсон ВКD-231 цооног байрлах структурын биетүүдийг шалган, өндөр агуулга бүхий бүсүүдийг тэлж нэмэгдүүлэхээр төлөвлөгдсөн.

Өмнө хийгдсэн эхний 240 цооног (ВКD-01-ээс ВКD-240)-г алт агуулсан хамгийн өргөн кварц-адулярын судлууд Мидфийлд бүсийн ВКD-98 болон ВКD-99 цооногуудад огтлогдсон (тус бүр нь 2.0 болон 1.7 метр өргөн). Энэ 2 цооног нь баруун хойш чиглэлтэй гүний хагарал болон солбицох хавтгайн структурын огтлолцол дээр өрөмдөгдсөн байдаг. ВКD-244 цооног нь ВКD-98 цооногоос зүүн зүгт ойролцоогоор 10 метр зайд өрөмдөгдсөн ба 108.3 метрийн гүнээс эхлэх 0.4-1.6 метр хүртэл зузаантай кварц болон кварц-адулярын 5 өргөн судлыг агуулсан 7.13 метр интервалыг огтолсон. Эдгээр судлуудыг агуулж буй 109-116 метрийн интервалд байх 7 метр нь дунджаар 34.4 г/т алттай. Эдгээр кварцын судлуудын бөөгнөрөл нь солбицох хавтгай болон баруун хойш чиглэлтэй структуруудын огтлолцол дээр хамгийн их ан цавшил үүссэн гэх структурын тайллыг дэмжиж байна. Энэ өрөмдлөгийн ажлын үр дүн нь 2018 оны 3-р улиралд төлөвлөгдсөн нөөцийн тайлантай холбоотойгоор Хойд Мидфийлд бүсийг тэлэх, геологийн үнэмшилт магадлалыг нэмэгдүүлэх ба Баян Хөндийн алтны системийн хүрээнд болон түүний ойр орчимд шинэ бүсүүдийг илрүүлэхэд чухал ач холбогдолтой боллоо.

2018 оны 2-р улирлын Баян Хөндий өрөмдлөгийн ажлын хөтөлбөр

Баян Хөндийд 2018 оны 2-р улирлын турш хийсэн нийт 4,545 тууш метрийн урттай 22 цооног (21 шинэ цооног, 1 сунгалтын цооног)-ийн үр дүнг 3 долоо хоногийн хугацаанд танилцуулна. Үлдсэн 9 цооног (8 шинэ цооног, 1 сунгалтын цооног)-ийн үр дүн нь 2018 оны 3-р улиралд

хийгдэх Баян Хөндий анхан шатны нөөцийн тайланд тусгагдан, хөндлөнгийн нөөцийн тооцоо хийх компанид хүргэгдэнэ.

Бүс нутгийн хайгуул

Сүүлийн жилүүдэд Компани нь Монгол Улсын баруун өмнөд хэсэгт хайгуул хийн, хэтийн төлөв бүхий 7 талбайтай шинэ алтны дүүргийг нээсэн (“Хөндий алтны дүүрэг”). Эдгээр талбайн 2 нь буюу Баян Хөндий, Алтан Нар нь өндөр хэтийн төлөв бүхий орд болгон хөгжүүлэх боломжтой төслүүд тул 2018 онд олон улсын эрдсийн стандартаар нөөц тооцоолохоор зорьж байна.

Алтан Нар нь Баян Хөндийгөөс хойд зүгт 16 км зайд орших дундлаг сульфидтай алт-полиметаллын орд бөгөөд боломжит нөөц нь дунджаар 2.8 г/т алттай дүйцэх (AuEq) агуулгатай 452,900 унц, таамаглагдсан нөөц нь дунджаар 2.5 г/т AuEq агуулгатай 277,100 унц бөгөөд нийт боломжит нөөц нь 5.0 сая тонн (“сая тн”), таамаглагдсан нөөц нь 3.4 сая тн хүдэрт агуулагдаж байна. Боломжит нөөцөд 317,700 унц алт (дундаж агуулга нь 2.0 г/т алт), 31,600 тонн (“тн”) цайр, 29,000 тн хар тугалга болон 2.35 сая унц мөнгө агуулагдаж байгаа бол таамаг нөөцөд 185,700 унц алт (дундаж агуулга нь 1.7 г/т алт), 23,700 тн цайр, 22,300 тн хар тугалга болон 865,900 унц мөнгө агуулагдаж байна (2018 оны 5-р сарын 10-ны мэдээ).

Өнөөдөр эхэлж буй региональ эрлийн өрөмдлөгийн ажил нь Баян Хөндийгөөс хойш 3.5 км зайд орших алт-мөнгөний Алтан Сум төсөл дээр 2017 оны 4-р улиралд эрлийн өрөмдлөгийн ажлаар илэрсэн алтны өндөр агуулгатай хэсгүүдэд дараагийн шатны нэмэлт өрөмдлөгийн ажил хийгдэхээр төлөвлөгдсөн. Өмнөх өрөмдлөгийн ажлаар AAD-12 цооногт 70 г/т алттай 2 м, мөн түүнээс гадна баруун зүгт 300 м зайд орших шинэ талбайг шалгахад гүехэн орших 1 метрийн 39 г/т алт (AAD-11) тус тус тогтоогдсон билээ.

Компани Алтан Сум төслөөс зүүн зүгт 2.5 км зайд орших Хойд Хөндий алтны хэтийн төлөвт талбайд анхан шатны өрөмдлөгийн ажлыг хийж гүйцэтгэнэ. Энэ талбайн хөрсний алтны аномаль нь 1 км урт үргэлжилдэг ба түүний хүрээнд халцедон болон штокверк кварцын судлууд, гематитийн брекчийн хэмхдэсүүд тархалттай байна. Эндээс авсан анхны чулуун дээжлэлтийн үр дүнгээр 22 г/т хүртэл алт илэрсэн байдаг. Энд соронзон бага гажилтай давхацсан хүчтэй иллитийн хувиралд орсон хэд хэдэн бүс тогтоогдсон бөгөөд түүнийг баруун урагш 3.5 км-т орших Баян Хөндийн төслийн талбайн хувиралтай адил төстэй гэж үзэж байгаа. Энэхүү зүүн хойш чиглэлтэй том структурын дагуу орших гол кварцын брекчийн бүсийг өрөмдлөгийн ажлаар шалгах болно.

Компанийн 100% эзэмшдэг алтны төслүүдээс гадна Баян Хөндий тусгай зөвшөөрлийн талбайн баруун залгаа орших 1,780 га Улаан хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбайн 51%-г Компани 100% хүртэл эзэмших нөхцөлтэйгөөр худалдаж авсан. Энэ хайгуулын талбайд урьд нь өрөмдлөгийн ажил болон суваг малталтын ажил хийж байгаагүй. Энэхүү талбайд 3 км диаметр бүхий маш өргөн, гүний, порфир төрлийн ордуудад тохиолддог хүчтэй

хувирлын бүс илэрсэн. Компани Улаан талбайн анхан шатны 2,500 метрийн өрөмдлөгийн ажлыг хийн гүйцэтгэх төлөвлөгөөг өнөөдөр эхлүүлж байна.

Мөн түүнчлэн Эрдэнэ нь Тек Ресурс Лимитэд компанитай хамтын ажиллагаа (“**Хамтын ажиллагаа**”)–г үргэлжлүүлэн Эдрэнгийн террейний порфир болон порфиртой холбоотой хүдэржилтийн хэтийн төлөв бүхий талбайг ялгах, бүс нутгийн эрлийн ажлаа үргэлжлүүлэн, Монгол улсын баруун өмнө хэсэгт хайгуулын ирээдүй бүхий талбай хамтран илрүүлэхийг зорьж байна. Баян Хөндий, Алтан Нар, Алтан Сум, Улаан, Хөвийн Хар болон Зуун Мод талбайнууд энэхүү хамтын ажиллагаанд багтдаггүй болно.

Мэргэшсэн этгээд (геологич) ба дээжлэлтийн протокол

Майкл МакДоналд (Michael A. MacDonald) нь Компанийн Хайгуул эрхэлсэн дэд ерөнхийлөгч, мэргэшсэн геосудлаач (P.Geo.) (Nova Scotia) бөгөөд NI 43-101-т заасан мэргэшсэн этгээд ба энэ мэдээлэлд багтсан техникийн мэдээллийг хянан баталгаажуулсан болно. Бүх дээжийг Улаанбаатар хот дахь Эс Жи Эс (“**SGS**”) лабораторид шинжлүүлсэн. Эс Жи Эс лабораторийн дотоод хяналт шалгалтаас гадна, Компани нь тусгай стандарт бэлдэц, хээрийн болон лабораторийн хуулбар, мөн хүдэржилтгүй бэлдцийг ашиглан дээжийн чанарын хяналт, баталгаажуулалт (“**QA/QC**”)–ын протоколыг гүйцэтгэсэн.

Бүх дээжид алтны агуулгыг стандарт Хайлуулах аргаар (fire assay), бусад 33 химийн элементийг Индукцын хос плазмт спектрометрийн арга (Inductively Coupled Plasma Optical Emission Spectroscopy) ашиглан тогтоосон. 5 г/т алтны агуулгаас дээш агуулга илэрсэн дээжүүдэд алтны шигшүүрийн шинжилгээ (screen-metallic алттай analysis) хийсэн ба энэ нь 500 г дээжний 75 микроноос бага байх 30 г бүхий 3 дээж болон 75 микроноос том байх хэсгүүдэд хийгдсэн алтны хайлуулах (fire assay) шинжилгээнүүдийн жигнэсэн дунджаар илэрхийлэгддэг.

Эрдэнийн дээжлэлтийн протокол нь (хүдэржилт болон чулуулгийн төрлөөс хамаарч) зарим нэг жижиг, хүдэржилтийн дараа үеийн чулуулаг болон хүдэржилтгүй боржинг алгассан, 1 эсвэл 2 метрийн интервалтайгаар, цооногийг бүтнээр нь хамарсан дээжлэлтээс бүрддэг. Дээжлэлтийн интервалыг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэдэг ба геологийн хяналт эсвэл хүдэржилтээс хамаардаггүй болно. Бүх дээжийг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэн алмазан хөрөөгөөр 2 тэнцүү хуваадаг. Хуваагдсан дээжийн талыг дээжний уутанд ялган авч дээжилдэг бөгөөд үлдсэн талыг нь дээжний хайрцганд үлдээн Компанийн Баян Хөндий дэх хээрийн ангид аюулгүй байдлыг ханган хадгалдаг. Бүх дээжийг нэг багцандаа 30 дээж байхаар хуваарилдаг ба багц болгонд стандарт бэлдэц, хүдэржилтгүй бэлдэц, лабораторийн хуулбар болон хээрийн хуулбар дээж буюу дээжийг 4 хуваан, 2-ыг нь 2 тусад нь дээжлэн хийж Улаанбаатар дахь Эс Жи Эс (“**SGS**”) лаборатори руу шууд тээвэрлэдэг. Тээвэрлэлтийг Эрдэнийн ложистикийн гэрээт компани Монруд ХХК гүйцэтгэдэг.

Компанийн тухай

Эрдэнэ Ресурс Девелопмент Корп. нь Монгол улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад улсад бүртгэлтэй хайгуулын компани юм. Компани нь Монгол улсын баруун урд бүсэд өндөр агуулга бүхий газрын гадаргад ойр Баян Хөндий алтны төсөл, Баян Хөндий төслийн талбайгаас 16 км зайд орших өндөр агуулга бүхий газрын гадаргатай ойр алт-полиметаллын Алтан Нар төсөл, Баян Хөндий төслийн талбайтай залгаа орших зэс-алтны порфирын хайгуулын Улаан талбай, Баян Хөндий төслийн талбайгаас хойд зүгт 3.5 км-т орших өндөр агуулга бүхий алт-мөнгөний Алтан Сум төсөл, хөгжүүлэлтийн эхний шатанд явж буй зэс-мөнгөний порфирын Хөвийн Хар төсөл, өндөр агуулга бүхий зэс-алтны Номин Тал нээлт, томоохон молибден-зэсийн порфирын Зуун Мод орд зэрэг төслүүдийн хүрээнд 4 хайгуулын, 1 ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг. Үүнээс гадна, Монгол улсын баруун урд зүгт, Транс Алтайн бүсэд Канад улсын Тек Ресурс компанитай хамтарсан бүс нутгийн зэс-алтны хайгуулын үйл ажиллагааг эрхэлж байна. Компани нь Баян Хөндий, Алтан Нар төслүүдийн тусгай зөвшөөрлүүдийн хүрээнд 2%-ийн борлуулалтын цэвэр ашгийн төлбөр (“NSR”)-ийг Сэндстормд төлөх үүрэгтэй бөгөөд төлбөрийг 1% хүртэл бууруулах боломжтой. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг Компанийн вебсайт www.erdene.com-оос авч, танилцах боломжтой. Эрдэнэ нь 157,682,041 ширхэг Энгийн хувьцаа, хорогдуулах боломжит 179,141,320 Энгийн хувьцаатай болно.

Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш болно. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.


ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.

Холбоо барих:


Петер С. Акерли, Ерөнхийлөгч болон Гүйцэтгэх захирал
Кэн В.МакДоналд, Дэд ерөнхийлөгч болон Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419
Емайл: info@erdene.com
Вебсайт: www.erdene.com
Твиттер: <https://twitter.com/ErdeneRes>

Зураг 1. Бүс нутгийн байршил



Зураг 2. Баян Хөндий алтны төсөл



Зураг 3. Баян Хөндий

